

## Тооно уулын нанхиад бичээсийн шинэхэн орчуулга

Докторант Ц.Ганбаатар  
/МУИС-ийн МХСС-ийн багш/

Хуучин Хан Хэнтий уулын аймгийн Дашбалбар уулын хошуу буюу эдүгээгийн Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших Тооно уулын өвөрт бүхий Буга хэмээх шовх уулын баруун урд бэлд байгаа жижиг толгойн нар мандах зүг рүү харсан том цохио чулууг дөрвөлжлөн ухаж, бидний энд авч үзэж буй нанхиад бичээс бүхий гэрэлт хөшөөг анх суулгасан байжээ. Энэхүү гэрэлт хөшөө одоо Үндэсний түүхийн музейд хадгалагдаж байгаа бөгөөд түүнийг анх манай нэрт эрдэмтэн, түүхч Х.Пэрлээ уул музейд авч ирсэн тухайгаа: "Энэхүү бичээс бүхий самбар чулууг 1955 оны өвөл цагт энэ өгүүллийг бичигч Улаанбаатар хотноо, Улсын төв музейд авчирч, үзмэрт тавьсан билээ"(1:5) хэмээн дурдсан байдаг. Археологич Д.Цэвээндорж, Б.Цогтбаатар нар 1993 онд Монгол - Японы хамтарсан "Гурван гол" шинжилгээний ангид оролцож явахдаа Тооно уулын хөшөөний суурийг очиж үзсэн тухайгаа "...Буга хэмээх шовх уулын баруун урд бэлд байгаа жижиг Толгойн нар мандах зүг рүү харсан том цохио чулууг "мод зөрөхтэй" адилаар 1м х 50 см харьцаатай дөрвөлжлөн ухаж 30 х 40 см зузаантай том хавтан чулууг суулгаж байсан суурь байлаа. Нутгийн хүмүүс төдийлөн энэ тухай мэдэхгүй байв. Буцаж ирсэн хойноо зарим холбогдох сурвалж бичгээс үзвэл энэ нь "Дайчин улсын Энх Амгалан хааны гурав дахь удаа цэрэглэн мордож бичээс үлдээсэн газар ажээ" (2:209-210) хэмээн тайландаа дурджээ. Манжийн Энх Амгалан хаан гурав дахь удаагаа цэрэглэн мордож, Зуун модны газраа Ойрадын Галдан бошогт хааны цэргийг 1696 онд дарсан үйл явдлаа тэмдэглэж уул бичээсийг үлдээсэн байна. (1:3) Энэхүү гэрэлт хөшөөний бичээс нь XVII зууны Монгол болон Ойрадын түүхэнд холбогдох чухал баримт бичиг төдийгүй Монгол нутаг дахь нанхиад бичгийн дурсгалын нэг болохын хувьд судлаачдын анхаарлыг татсаар ирсэн нь зүйн хэрэг юм.

XIX зууны дунд үед хятадын эрдэмтэн Жан Му-гийн туурвисан " "Монголын нүүдлийн тэмдэглэл" хэмээх номд уул бичээсийн тухай дурдсан байдаг ажээ. (1:3) Түүнчлэн уг хөшөөний үг манжийн Энх Амгалан хааны "Биеэр дайлж, өрнө умрын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг"-ийн манж, монгол, нангиад эхэд байдаг билээ. Шинжлэх ухааны хүрээлэнгийн жинхэнэ гишүүн, нэрт манжич Бат-Очир шадар 1920-оод онд Хэнтий аймагт шинжилгээний ажлаар явахдаа уул хөшөөний бичээсийн хуулбарыг авч ирсэн ажээ. (1:3) Түүхч, доктор Х.Пэрлээ 1960 онд нийтлүүлсэн "Тооно уулын хятад бичээс" (2) хэмээх товхимолдоо уг хөшөөний бүдэг гэрэл зураг, бичээсийн гар сийрүүлэг болон 1920 онд нэр нь үл мэдэгдэх хүний хийсэн орчуулга, "Дай-цин-и-тун-жи" хэмээх номд орсон эхээс Б.Баганын 1947 онд хийсэн орчуулга, Оросын эрдэмтэн Тимковскийн орос орчуулга зэргийг тус тус нийтлэн, судлаачдын сонорт өргөн барьсан байна. (1:4-5)

Эрдэмтэн Э.Пунцаг 1976 онд нийтлүүлсэн "Тооно уулын бичээсний шинэ хуучин орчуулга" (3) хэмээх өгүүлэлдээ "Биеэр дайлж баруун хойт хязгаарыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг"-ийн манж эхээс 1904 онд монгол бичгээр буулгасан Агваан, Лувсаннамжил нарын зэрэг 9 хүний орчуулга, ШУА-ийн Дорно дахины судлалын хэлтсийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Түмэнжаргалын төв музейд байгаа уул хөшөөний бичгийг Х.Пэрлээгийн нийтлүүлсэн хуулбартай тулган уншсан орчуулга, Улсын Төв архивын манжич Л.Пэрлээгийн нийтлүүлсэн хуулбартай тулган уншсан орчуулга, Улсын Төв архивын манжич Л.Должинсүрэнгийн манж эхээс орчуулсан орчуулгыг МУИС-ийн манж хэлний багш Ц.Шархүүгийн хянан сийрүүлсэн хувилбар зэрэг гурван орчуулгыг шинээр нийтлүүлсэн нь энэхүү хөшөөний бичгийг цаашид нягтлан судлахад чухал ач холбогдолтой ажил болжээ. Тэрбээр эдгээр орчуулгын онцлогийн талаар ч товч өгүүлсэн байна. Хамгийн сүүлд 1999 онд Улаанбаатарт хэвлэгдсэн "Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал" хэмээх хамтын бүтээлд түүхч, эрдэмтэн С.Цолмон "Тооно уулын бичээс" хэмээх товч тайлбар нийтлүүлэв.

Эдүгээ үндэсний түүхийн музейд хадгалагдаж байгаа уул хөшөөг бид биечлэн үзэж, дахин нягтлан унших оролдлого хийснээ одоо толилуулъя.

Энэхүү хөшөөний урт 1,25 см, өргөн 51 см бөгөөд баруун гараас зүүн гар тийш долоон мөр нангиад бичээсийг дээрээс доош босоо байдлаар бичжээ.

Хөшөөний гурав хуваасны нэг буюу дээд хэсэг цуурсан бөгөөд мөн баруун гар талын дээд үзүүр хагарч гэмтсэн байна. Энэхүү цууралт 1-р мөрийн 𐎆, 2-р мөрийн 𐎇, 3-р мөрийн 𐎈, 4-р мөрийн 𐎉, 5-р мөрийн 𐎊, 6-р мөрийн 𐎋 зэрэг ханзыг дайрсан боловч уншихад тодорхой байгаа юм. Мөр тус бүрт орсон ханз үсгийн тоо харилцан адилгүй, тухайлбал, 1-р мөр 14 ханз байснаас хамгийн сүүлчийнх нь балран үгүй болжээ. 2-р мөр, 7-р болон 3-р мөр 14 ханз байгаагийн хамгийн сүүлчийн ханзны хэсэг үлдсэнийг судлаачид хэмээн сэргээсэн байна. 4-р мөр 14 ханз, 5-р мөр 4 ханз, 6-р мөр 14 ханз, 7-р мөр 6 ханз буюу нийт 73 дүрс үсгээр уул бичээсийг тэмдэглэжээ.

**Хөшөөний бичээсийг орчуулсан бидний орчуулга:**

**1-р мөр:** Их Чин (улсын) Хуанди Өөлдийн Галданг дайлаар мордож түр буудаллав.

**2-р мөр:** Тооно уулнаа хаан бээр тэмдэглэж сийлүүлсэн бичээс.

**3-р мөр:** Говь Хангай зэрэглээтэн долгиолно

Хэрлэн гол гүн бөгөөд цэлгэр

Өөрийн биеэр зургаан бүлэг (цэрэг) авч

Бидний сүрийг (цог жавхлан)

**4-р мөр:** Илтгэн бадруулж,

Түрхрэх аянга, нижигнэх мөндөрийн сүрээр айлгаж

Наран сарны гэрлээр

Догшин муус ад зэтгэрийг устгаж

**5-р мөр:** Алс зэлүүд нутгийг

Амаржуулан тогтоов.

**6-р мөр:** Энх-Амгалангийн гучин тавдугаар он, улаан

хулгана жил, таван сарын улаан луу

**7-р мөр:** шинэтгэл арван хоёрын өдөр, улаагчин туулай.

Бидэнд одоогоор мэдэгдээд байгаа орчуулгын үг хэллэгийг жинхэнэ эхтэй тулган үг утгын хувьд тохирох ба үл тохирох газруудыг олж нягтлан доор сийрүүлбэл:

1920-иод оны нэр нь үл мэдэгдэх хүний орчуулгад, "Хангай" гэдэг үг байхгүй.

"Хэрлэн гол" гэж байхгүй. "Зургаан бүлэг" (цэрэг) гэж байхгүй.

Баганын 1947 оны орчуулгад, "Эзэн зургаан хуаран цэргээ дагуулж" гэдгийг онцлох!

Тимковскийн орос орчуулгад, "Хангай говь зэрэглээтэн долгиолох" гэхийг "Необозирима великая степь" ("Нүд алдам их тал хязгааргүй"), "Ведомые мною шесть воинств.-миний удирдсан зургаан цэрэг"-энд утга санааг эрс гажуудуулжээ.

"Биеэр дайлж өрнө умрын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг"-ийн монгол орчуулгад, "Говь хангай долгиотоно" гэхийг "Говийн газар өргөн уудам" гэж, "Хэрлэн гол гүн бөгөөд цэлгэр гэхийг "Хэрлэний ус товойж мэлмэлзгүй гэв."

"Өөрийн биеэр зургаан бүлэг (цэрэг) авч" гэхийг биеэр их цэргийг авч" гэв.

1904 онд Манж хэлнээс хийсэн Монгол орчуулгад, "Говь хангай зэрэглээтэн долгиотоно" гэхийг "Говийн газар өргөн уудам" гэв. "Зургаан хэсэг цэргийг" "Их цэрэг" гэв.

Б.Түмэнжаргалын орчуулгад, "Элсэн говийн нутаг өргөн болоод уудам Хэрлэн голын ус гүн болоод цэлгэр" гэсэн нь бидний уншилттай тохирч байна.

"Зургаан хэсэг цэрэг" гэхийг "Их цэрэг" гэсэн байна.

"Аяа нар сарыг хүртэл хэлмэн догдлуулж" гэдэг нь "Наран сарны гэрлээр Догшин муус, ад зэтгэрийг устгаж" гэдэгтэй үл тохирч байна.

Л.Должинсүрэнгийн манжаас хийсэн орчуулгад, "Говийн газар өргөн уудам" гэдэг нь "Говь хангай зэрэглээтэн долгиолно" гэдэгтэй тохирохгүй байгаа юм.

"Хэрлэнгийн ус давлан мэлмэлзэх" гэдэг нь "Хэрлэн гол гүн бөгөөд цэлгэр" гэдэгтэй үл тохирно. "Зургаан бүлэг цэрэг" гэдэг нь "Их цэрэг" гэдэгтэй үл тохирч байна.

**Эцэст нь товч дүгнэхэд:**

1. Дурдаж буй бичээсийн дээрх долоон орчуулгад хоёр дахь, гурав дахиаас бусад бүх орчуулгад "Их цэргийг авч" гэжээ. Энэ нь бидний бодоход 六 (зургаа) гэсэн дүрс үсгийг 大 (их) гэсэн дүрс үсэгтэй андуурсан бололтой. Учир нь уул хөшөөний бичээст 大清 (Их Чин) хэмээх үгийн 大 /их, том/ гэсэн ханз тов тодорхой сийлээстэй байгаа билээ.

2. Өгүүлж буй хөшөөний бичээст Говь, Хангай хэмээн тодорхой өгүүлсэн байх бөгөөд, нөгөөтэйгүүр, Энх-Амгалан хааны цэрэг Галдан бошогтын цэрэгтэй их говийг туулан ирж Хэрлэн мөрөн, Зуун мод, Тооно уул, эдүгээгийн Тэрэлж орчмын нутгуудад их тулалдаан хийснээс үзэхэд Хангай гэдэг үг байх нь зөв мэт санагдана.

3. Уг эхэд буй "Хэрлэн гол гүн бөгөөд цэлгэр" гэснийг нэг дэх орчуулгад ор тас орхиж, хоёр дахь орчуулгад "Хэрлэн мөрний долгион мэт", дөрөв дэх орчуулгад "Хэрлэний ус товойж мэлмэлзмүй", тав дахь орчуулгад "Хэрлэний ус давлан мэлмэлзмүй" хэмээн тус тус орчуулсныг тулган уг эхийг барин шинэхэн орчуулгандаа орууллаа.

Энх Амгалан хаан Өөлдийн Галданг дайлаар мордсон тухай бичээсийг Монгол нутагт хэд хэдэн газар үлдээсний дотор Цагаан уул, Тооно уул, Тэрэлжийн орчим Алтан гадас, гурван газар тэмдэглэн үлдээсэн мэдээ түүхийн сурвалжуудад олонтой тэмдэглэгдсэн байдаг. Ийн 300-аад жилийн өмнө үлдээсэн эдгээр бичээсээс одоо бидэнд мэдэгдээд байгаа Тооно уулын бичээсийн хуулбар болон уншилт, орчуулгад буй алдаа мадагийг нягтлан залруулж, дахин нийтлэн эрдэмтэн судлаач, шинжээч нарт толилуулсу.

**The new translations of the inscription in Toon mountain.**

**Summary**

*By Ts. Ganbaatar*

In this article are included the collected scientific reviews of studies and new documents such as accounts from archives, petitions, archeological surveys and reports, new proceedings. We compared and analyzed the existing 7 translations of this inscription in Mongolian, Russian and Manchu with original inscription and interpretation. Here we present our new translation.

**Ашигласан ном зохиол**

1. Х.Пэрлээ, Тооно уулын хятад бичээс "SA". t.l.,f.9. УБ. 1960. 6 тал
2. Д.Цэвээндорж, Б.Цогтбаатар, Монгол-Японы хамтарсан "Гурван гол" шинжилгээний ангийн археологийн хэсгийн тайлан. УБ. 1993 он. ШУА-ийн Түүхийн хүрээлэн. Гар бичмэлийн хөмрөг.
3. Э.Пунцаг, Тооно уулын бичээсний шинэ хуучин орчуулга. "SE" t.Y.,f.1-9. УБ. 1976. 134-139 тал
4. Тооно уулын бичээс. "Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал" УБ. 1999. 227-228 тал
5. Биеэр дайлж өрнө умрын газрыг төвшитгэн тогтоосон бодлогын бичиг (Алшаа зүүн хошууны Ардын Засгийн ордон зохион байгуулж эмхэтгэв). "Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо" Хөх хот. 1992. 888 тал.